

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН  
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ  
(Шинэжинст сум)**

2023 оны 12 дугаар сарын 15

Залаа

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Суурь түвшин	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8	9
<b>2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>								
1	2.1.1. Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	1. Анхан шатны 24 нэгжийн эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	2021 - 2024	60	ШИНЭЖИНСТ СЭМТ -ийн эмнэлэгийн тоног төхөөрөмжийн зардаалаас	90	Шинэжинст сумын ЭМТ-нь 2022 онд ард иргэдэд анхан шатны тусlamж үйлчилгээ үзүүлэхэд лабораторийн аппаратын оношилгоо шинжилгээ хийх хүчин чадлын хувьд дутмаг байсан. 2023 онд өөрийн эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн зардаас харьялах хүрээний хүн амд орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн оношилгоо шинжилгээг хийх зорилгоор шээсний шинжилгээний /certificate og qualityH-3/, иммунологийн /Genru- FA50/аппаратыг тус тус худалдан авч ажиллаж байна. Биохими болон гематологийн аппаратуудын гадаад болон дотоод хяналтуудыг хийлгэж, бусад урвалж бодис болон түргэвчилсэн оношлуураар ханган лабораторийн н хүчин чадлыг хэвийн горимд ажиллуулж байна.	100%
2	2.1.2. Эрэгтэйчүүдэд	1. Цэргийн насын 18-25 насын	2021 - 2024	200		200	Цэргийн насын 18-25 насын эрчүүдийг шинжилгээнд бүрэн хамруулахад	95%

1	2	3	4	5	6	7	8	9
	чиглэсэн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчинийг бэлтгэн, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулж, өвчлөлийг илрүүлж, эрүүлжүүлэх					шинжилгээнд өөрчлөлттэй гарсан 20 иргэнийг эмчлэн эрүүлжүүлсэн 10 цэрэг цэрэгт татагдсанаас 8 цэрэг тэнцэж цэргийн албанад явсан. 2 нь шалтгаан тодорхойгүй. Цэргийн насы 18-25 насын эрчүүдийг эмчийн үзлэгт бүрэн хамруулж нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгож сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан. Цэрэг татлагын талаарх мэдээ мэдээлэл, видео шторкийг “Залаажинст” болон Эрүүл мэндийн төвийн цахим хуудсанд байршуулж, иргэд болон цэргийн насын залууст үнэн зөв мэдээлэл өгсөн байна.	
3	2.1.3. “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшилаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	2. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	2021 - 2024	4.8	465.000	3.5	Байгууллагын 15 ажилтан аймгийн нэгдсэн эмнэлэгт очиж шинжилгээ өгч сүрьеэ өвчний урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамрагдаж эрүүл гэсэн оноштой гарсан.	90%
4	2.2.2. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга	1. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга	2022 - 2024	0	8000000 сая төгрөг	100	Шинэжинст сумаас хамгийн тасралтгүй идэвхитэй хамрагдсан Ахмад настангууд, З Гэр бүлүүд идэвхитэй хамрагдлаа. Энэхүү аяныхаа	100%

1	2	3	4	5	6	7	8	9
Хэмжээг хэрэгжүүлнэ.	хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх						хүрээнд Баянхонгор аймагтаа Шинэжинст сум 3-р байрт шалгарсан. “ЭРТЭЧ ИДЭВХТЭЙ БАЙГУУЛЛАГА” төрөлд: •Цэцэрлэгийн хамт олон •Хүүхэд “ЭРТЭЧ ИДЭВХТЭЙ ГЭР БҮЛ” төрөлд: •Ш. Энхчимэг З хүүхдийн хамт: Баатаржав, Ю.Нацагдорж “ЭРДЭНЭТ СҮРГИЙН ЭЗЭД- 1000” чуулган урлаг, спортын наадамд 50 малчдыг хамруулж оролцуулсан.Шинэжинст сум нийлбэр дунгээрээ 7-р байрт шалгарсан. 2023 оны 9 дүгээр сарын 28-30-ны хооронд сумын нийт ард иргэдийн дунд Намрын спартакиадын тэмцээнийг 14 төрлөөр зохион байгуулсан. Нийт нийлбэр дунгээр М.Болдцэрэн даргатай Уртын гол 2-р багийн хамт олон 1-р байр, эзэлж Цом 2000000₮ шагнасан. Хоёрдугаар байранд Б.Ангирмаа даргатай Эрдэнэшанд 3-р багийн хамт олон 1,500000₮ шагнасан. Д.Энхдалай даргатай Зараа 1-р багийн хамт олон 3-р байранд орж 1,000,000 төгрөгөөр шагнасан. Дөрөвдүгээр байранд Д.Дашжамц даргатай Эхэнхавцгайт 4 дүгээр багийн хамт олон 500,000₮, шагнасан. Спортын төрөл тус бүрд медаль гардуулж, тамирчидаа шагнасан. Намрын спартакиадад 1 хүн 2 төрөлд оролцож, нийт давхардсан тоогоор 120 ард иргэд оролцсон. Үүнээс эрэгтэй- 55, эмэгтэй- 65 тамирчид оролцсон. Намрын спартакиадад зарцуулсан мөнгө 7000000 төгрөг ТЕННИСНИЙ ТӨРӨЛД: 1-р байр : С. Хишигтогтох алтан медаль 2-р байр : Э.Дүүрэнхундага мөнгөн медаль 3-р байр : Б.Бямбасүрэн хүрэл медаль, ВОЛЕЙБОЛ /эрэгтэй/ ТӨРӨЛД : 1-р байр Б.Данаажав ахлагчтай баг тамирчид 2-Р байр М.Машбат ахлагчтай баг тамирчид 3-р байр:	

1	2	3	4	5	6	7	8	9
							Б.Сэргорж ахлагчтай баг тамирчид хүрэл медаль Шинэжинст сум 2023 оны аварга шалгаруулах тэмцээн 11 сарын 15-17 нь өдрүүдэд болсон. Спортын 12 төрлөөр зохион байгуулсан. Нийт 755 тамирчид оролцсон.	
5	2. Спорт заалуудын ашиглалтыг сайжруулах	2021 - 2024	20000	873 сая	20000		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Спорт заал" шинээр барих ажлыг "Буян арвижих од" ХХК 873 сая төгрөгөөр бүрэн дуусаж хийж гүйцэтгэсэн. 2022 оноос ажил эхэлж нийт гүйцэтгэх ажлын 80%-ийг хийж, 2023 онд үлдэх 20%-ийн ажлыг бүрэн гүйцэтгэж дуусган аймгаас мэргэжлийн байгууллагаас хариуцсан мэргэжилтнүүдийг авчирч газар дээр нь шалгуулан дутуу байсан ажлуудыг гүйцэн орон нутагт хүлээлгэн өгсөн.	98%
6	3. Заал, талбайн засвар үйлчилгээ хийж, шинээр ашиглалтад оруулах	2021 - 2024	2 0 0	1367898542 төгрөг	2 1 0		Биеийн тамирын гадаа талбай байгуулах ажлыг Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn сайтаар нээлттэй тендер зарлан "Элбэг констракшн" ххк-2023-2024 онд 1367898542 төгрөгөөр ажлыг хийж гүйцэтгэх гэрээ байгуулан 2023 онд хийх ажлаа бүрэн хийж гүйцэтгэсэн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлсэн. Энэ ажлын гүйцэтгэлд Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын ажлын хэсэг томилогдон ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан.	100%
7	2.3.2. Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ.	1. Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг чадваржуулах сургалтад хамруулах	2021 - 2024	96	0	40	Тусгай хэрэгцээт боловсролын багшаар Б.Цогзолмааг томилон сумын нийгмийн бодлогын ажилтантай хамтран судалгаа гаргаж 2-4 настай 3 тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн эцэг эхэд туслан зөвлөх үйлчилгээ үзүүлэн эцэг эхэд дасгал даалгаврыг өгч ажиллаж байна.	80%
8	2.3.3. Сургуулийн	3. 5 настай хүүхэд бүрийг СӨБ-ын	2021 - 2024	97	0	100	Сумын хэмжээний 5 настай нийт 43 хүүхдээс байгаагаас 35 нь үндсэн булэгт хамрагдсан ба	90%

1	2	3	4	5	6	7	8	9
	өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ.	үйлчилгээнд хамруулах					8 хүүхэд хувилбарт сургалтад хамрагдсанаас ирэн очин дасгал даалгавраа авч үндсэн булэгтээ ээлжлэн хамрагдаж байгаа. Сургуулийн өмнөх насны 5 настай хүүхдийн хамран сургалт 100%-тай байна.	
9	2.3.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ.	1. Тэгш хамран сургах дүйцсэн хөтөлбөр, бичиг үсгийн сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх	2021 - 2024	250		650	2018 оны 04 сарын 03 өдөр Дугаар А/168 Бага, сурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023-2024 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрөөр 15 суралцагчидтай хичээл сургалтын үйл ажиллагааг явуулж байна. 15 суралцагчийн эцэг эх, сургуулийн захиргаатай гуравласан гэрээ байгуулж ажиллаж байна. Сургалтыг суралцагчийн мэдлэг, чадварын түвшин, суралцах боломжид үндэслэн сургалтын бас нэг хэлбэр болох бие даах, зайны, гэрийн буюу шавь сургалтын хэлбэрээр мэдлэг, чадвараар эзэмшиж байна. Энэ хугацаанд 2023 оны 1 сарын 20-25 ны өдрүүдэд нийт 7 сургалцагчийн ар гэрээр айлчлал хийж, бие даалтыг шалгаж, нэмэлт даалгавар, ном сурах бичгийг өгч ажилалаа. Мөн Хүмүүжлийн зэрэг арга, гэр бүлийн сургалт, боловсролын тухай хуулиас сургалт хийж ард иргэдэд мэдээлэл хүргэсэн. Багийн Засаг дарга нартай хамтарч бичиг үсгийн сургалтыг нэг удаа зохион байгуулсан. 2-р багийн 4, 3-р багийн 2, сумын төвд байдаг 1, нийт 7 иргэдийн ар гэрээр айлчлал хийж.	100%

1	2	3	4	5	6	7	8	9
10	2. Насанд хүрэгчдийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх	2021 - 2024	5000 0	15000 2	даалгавар өгч ажиллалаа. Үүний үр дүнд 7 иргэн ангид ирж 4 удаа сургалт авсан. Анхан шатанд 2 эмэгтэй, Дунд шатанд 3, 1 эмэгтэй Гүнзгий шатанд 2 иргэн хамрагдаж байна. 7 иргэнээс эмэгтэй 3 үүний үр дүнд Гарын үсгээ зурж сурсан мөн цөөн тооны үг уншиж сурсан "Алхам алхмаар" аяны мэдээллийг тухай бурд нь Шинэжинст сумын насан туршийн боловсролын группд байршуулж байна. 8а ангид нэг удаа хичээл орж Алхам алхмаар цахим хуудаст нэгдүүлж 20 сурагчаар тест сорил туршилт хийж би ямар мэргэжилтэй болбол зохиох талаар сорил авлаа. "Миний эрхэмлэх үнэт зүйл, миний мэргэжил постер уралдаан"-д 9-р ангийн 5 сурагчийн постер, 8-р ангийн Эсээ бичлэгт 2 сурагчдын бүтээлүүдийг дараагийн шатанд оролцуулсан. 6-9 ангийн сурагчдын дунд Волейболын тэмцээн, Усны өдөр, Мазаалайн өдрүүдийг угтан ханын сонин хийх ажлыг 2 удаа зохион байгуулсан. Нийт давхардсан тоогоор 14 анги ханын сонин хийж оролцсон. Үйлдвэрчний эвлэлийн дарга Ц.Хуяг "Хөдөлмөрийн тухай хууль"-аар захиалгат сургалтыг 2023 оны 02 сарын 16нд соёлын төвд нийт 54 төрийн албан хаагч оролцов. Сумын эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтарч "Нандин холбоо" арга хэмжээн дээр "Эмэгтэйчүүд гэж хэн бэ" "Эмэгтэйчүүд гайхамшигт ертөнц" гэсэн лекцүүдийг 68 иргэнд уншилаа. Дэлхийн мөнгөний долоо хоног Цахим сургалтад 20 сурагчдыг хамрууллаа. Мөн ХААН БАНК-тай хамтарч 7-9 ангийн нийт 58 сурагчдад "Мөнгө, мөнгөний үнэ цэнэ", "Санхүүгийн боловсрол" сэдвээр сургалт орсон. Насан туршийн	100%		

1	2	3	4	5	6	7	8	9
							боловсролын 5 чиглэлээр нийт 19 төрлийн сургалтыг 505 иргэнд явуулсан. 2023 оны 10 дугаар сарын 26-27 өдрүүдэд 8-р ангийн 31 сурагчдад “Өөрийгөө таньж мэдэх” “Миний зан төлөв темперамент” “Сонирхлоо зөв тодорхойлох” “Үнэт зүйл” гэсэн 4 багц сургалт, “Дэлхийн хуримтлалын өдөр - 2023” хүрээнд Баянхонгор аймгийн Насан туршийн боловсролын төв, Монгол банктай хамтарч Цахим сургалтад 8-9 ангийн 40 сургачид, Хадгаламж ба Хуримтлал “Мөнгөө өсгөх арга” сэдэвтэй “хичээлүүдийг 6-7 ангийн 70 сурагчдад тус тус зохион байгуулсан. 1-5 ангийн АУБ нарт анги ангидаа 10-15 минут “Гар угаалт ”-ын талаар хичээл орох тухай мэдээлэл хийлээ. 4-р ангийн Д.Ганболор багш ангидаа хичээл орж гар угаахын ашиг тусын талаар хэрэгтэй зөвлөгөө өгсөн.	
11	2.6.1. Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэн сурталчилна.	1. Түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах	2021 - 2024	10	1.500.000	8	Орон нутаг судлах танхимыг бүрэн камержуулсан. Мөн Түүх соёлын дурсгалт газруудыг багийн дарга нар болон ойролцоо малчидтай хамтран ажиллах гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Орон нутгийн хамгаалалтад байдаг Шарилын овооны хоёр бунханг хайлсжууллаа. Хайлсжуулах ажлыг сумын СЭКЕРРЕСОРСУС МОНГОЛИА ХХК-ны санхүүжилтээр 1,500,000 төгрөгөөр уг газрыг хайлсжуулж ажиллаа.	100%
12	2.8.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг	1. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх	2021 - 2024	3.2	400000	25	Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн хэргийг үндэсний бичгээр эрхлэн гаргах чадварыг хөгжүүлэх, зорилгоор “Хос	70%

1	2	3	4	5	6	7	8	9
	хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна.						бичигтэн" төрийн байгууллага шалгаруулах" ажлын төлөвлөгөөг гарган, удирдамжийн дагуу тодорхой ажлуудыг зохион байгуулсан. Уг тайланг Баянхонгор аймгийн уралдаанд оролцуулахаар хүргүүлсэн. Нийт 90 орчим төрийн албан хаагч оролцсон.	
<b>3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>								
13	3.1.4. Тунгалаг санхүү хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2. Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагналт, баталгаажуулалтын хувийг нэмэгдүүлэх	2021 - 2024	80	байхгүй	83	Тус суманд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 52 ААНБ, Төрийн бус байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн ирцийг 100% хангуйж e-balance.mof.gov.mn сайтад 2023 оны 02 дугаар сарын 10 дотор хугацаанд нь шивж илгээсэн байна.	100%
14		3. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлэх	2021 - 2024	40		53	Сумын хэмжээнд 52 ААНБ, ТББ-н 23 аж ахуй нэгжүүд экспел файл ашиглан санхүүгийн тайлангаа гаргаж байна. Цаашид санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлж ажиллахыг төлөвлөж байна.	50%
15	3.3.2. "Хариуцлагатай уул уурхай-Эдийн засгийн үндэс" сургалтыг уул уурхай бүхий сумдын иргэдэд зохион байгуулна.	1. Уул уурхай бүхий сумдын иргэдэд сургалт зохион байгуулах	2021 - 2024	0	0	8	Сумын хэмжээнд 4 багийн иргэдийн нийтийн хурлыг хамтатган хийсэн бөгөөд уул уурхайн асуудал болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хүрээнд хийж нийт 1050 иргэн хамрууллаа. Багуудын Иргэдийн нийтийн хурал 2023 оны 10 дугаар сарын 13-наас 2023 оны 15-ны өдрүүдэд зохион байгуулгаждаж, иргэдэд төрийн албан хаагчид сургалт мэдээллийг хүргэсэн ба Байгаль орчин, уул уурхай, хог хаягдал, үндны усны чиглэлээр мэдээлэл, сургалтыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч баг тус бүр 1 удаа хийж, Зараа 1 дүгээр багийн Иргэдийн нийтийн хуралд 53	100%

1	2	3	4	5	6	7	8	9
							өрхийн 68 иргэн , Уртын гол Багийн Иргэдийн нийтийн хуралд 104 өрхийн 136 иргэн, Эрдэнэшанд багийн Иргэдийн нийтийн хуралд 89 өрхийн 106 иргэний төлөөлөл хуралд оролцож нийт 310 иргэнд сумын Байгаль орчны чиглэлээр хийгдэж байгаа болон цаашид хийгдэх ажлууд, Байгаль орчны холбоотой хуулийн танилцуулга, мэдээлэл хийгдсэн. Сумын хэмжээнд 4 багийн иргэдийн нийтийн хурлыг хамтатган хийсэн бөгөөд уул уурхайн асуудал болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хүрээнд хийж нийт 1050 иргэн хамрууллаа.	
16	3.3.4. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч нөхөрлөл, хоршоо болон иргэдэд хүрээлэн буй орчны эрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах.	2021 - 2024	53	0	25	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч нөхөрлөл, хоршоо болон иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах. ажлын хүрээнд нөхөрлөл байгуулах зорилготой 9 иргэн зөвлөмж мэдээлэл авсан. Бичил уурхайн үйл ажиллагаа энэ онд явагдаагүй.	100%
17		2. Бичил уурхай эрхлэгчдийг хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж, хяналт тавих	2021 - 2023	4	байхгүй	2	Бичил уурхай эрхлэгчдийг хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, хяналт тавих зорилтын хүрээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох ямар нэгэн үйл ажиллагаа явагдаагүй, хүсэлт гаргасан ямар нэгэн нөхөрлөл байхгүй.	100%
18	3.3.5. Эвдэрсэн газрын тооллого	1. Аймгийн хэмжээний	2021 - 2024	0		15	Аймгийн хэмжээний эвдэрсэн газрын тооллого судалгаанд нөхөн сэргээлт хийх ажил	100%

1	2	3	4	5	6	7	8	9
	судалгаан дээр үндэслэн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.	эвдэрсэн газрын тооллого, судалгаанд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах					тусгагдаагүй. Хайгуулын өрөм тавьсан "Эрдэнэмонгол" ХХК, "Сэker ресорсус Монголиа" ХХК -үүд нөхөн сэргээлтийг хийж орон нутагт хүлээлгэн өгсөн.	
19	3.6.1. Мал сургийн шилэн сонголтын ажлыг сайжруулж, малын ашиг шимиин түвшинг нэмэгдүүлж, малчдын мэдлэгийг дээшлүүлнэ.	1. Малын шилэн сонголтын ажлыг ўе шаттайгаар зохион байгуулж орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглан ашиг шимиийг нэмэгдүүлэх	2021 - 2024	40	39,0	70	2023 оны намрын үзлэг ангилалтаа 501 толгой ухна, 180 толгой хуц, 263 толгой Залаажинст-Эдрэн үүлдрийн ямаан сүргийн хээлтэгчид хийлээ. Мөн Баянбулаг омгийн хонин сүргээс бойжуулсан 30 толгой хуцыг тээвэрлэн авчирч малчдад түрээсийн гэрээгээр ашиглуулж байна. Мөн.govийн бүсийн 5 сумд 80 толгой Залаажинст-Эдрэн үүлдрийн хээлтүүлэгчийг тогтвортой ноолуур төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр нийлүүлээд байна. Төсөвт өртөг 18 сая төгрөг.	100%
20		3. Малчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	2022 - 2024	0		100	Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан Эрдэнэт сургийн эзэн -1000 спорт, урлагийн наадамд 50 малчин оролцож багийн дунгээр 5 дугаар байрт шалгарлаа. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан залуу малчдын улсын зөвлөгөөнд 2 малчин оролцлоо. 2023 оны 10 дугаар сард мал аж ахуйн багуудын хурлыг хийж өвөлжилт болон цаг үеийн мэдээллийг хүргэж санал хүсэлтийг сонслоо. Энэ арга хэмжээнд 324 малчийн өрхийн төлөөлөл хамрагдлаа.	100%
21	3.6.2. Мал эмнэлгийн чанар хүртээмжийг	1. Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх,	2021 - 2024	3	485000 төгрөгийг Засаг даргын нөөц		Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг улирал, хагас жилээр тайлагнан гүйцэтгэлийг цахим системд оруулсан. Энэ онд халдварт өвчнөөс	100%

1	2	3	4	5	6	7	8	9
сайжруулж, эрүүл бүс статусаа бататгана.	урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, угаалга туулгалтад мал сүргийг хамруулах				хөрөнгөнөөс шийдвэрлүүлсэн.	2	урьдчилан сэргийлэх 5 төрлийн дархлаажуулалтанд Шөвөг яр-1000, Дотрын халдварт хордлого- 3000, Бoom- 400, Галзуу – 2400, Цусан халдвэр-1000 нийт 9800 хамрагдахаас 9800 мал хамрагдаж гүйцэтгэл 100 хувтай дархлаажуулалтад хамрагдлаа. Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд 9800 толгой мал сүргийг төлөвлөн оруулж гүйцэтгэлийг бүрэн оруулсан. Нийт дархлаажуулалтад хамрагдсан малчин өрхийн 30 хувь ба 14 малчин өрхөөр явж хяналт тавьж ажиллалаа. Малчин өрхийн малын эрүүл мэндийн дэвтрийн бичилтийг тарилгын жагсаалттай тулган үзлээ. Мөн зарим чиглэлд хамтран явж ажиллалаа. Сумын ИТХ-н тогтоолоор баталсан төлөвлөгөөг Мал эмнэлгийн нэгдсэн цахим программд оруулан ажиллаж байна. Шимэгч өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд “Бодиос-Кашмер” үйлчилгээний нэгж туулгалтад- 10250, угаалгад- 30100, боловсруулалтад - 10100 толгой мал амьтан, “Зах гурван бамбуу” үйлчилгээний нэгж угаалгад-40100, туулгалтад- 10250, боловсруулалтад-10100 толгой мал амьтныг хамруулахаар хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд шимэгчтэх өвчнөөс сэргийлэх, эмчлэх арга хэмжээний гүйцэтгэлийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд тухай бүр оруулан ажиллалаа. Мал эмнэлгийн тасгийн 2 мэргэжилтэн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдвэрүүлж авсан Дук автомашинаар Мал эмнэлгийн тасгийн 2 мэргэжилтэн 09, 10 дугаар сард “Цармын цагаан сувд” хоршооны 36 малчин өрхийн 9980 мянган малыг	

1	2	3	4	5	6	7	8	9
							хамруулан технологийн дагуу угаалгын ажлыг гүйцэтгэлээ. Мөн 07 дугаар сард “Бодиос-Кашмер” ХХК-ийн малын эмч, туслах ажилтны хамт хоршооны өрхүүдээр явж мотопомпоор малыг шүршиж угааж угаалгад хамрууллаа. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх хавар, намрын дархлаажуулалтыг сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зардлыг шийдүүлэн 485000 төгрөгний шатахуун зарцуулан 501 үхэр таригдсан.	
22	2. Мал эмнэлгийн бүртгэл мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулж, мал болон малын гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавих	2021 - 2024	0	0	7000		Энэ онд мал эмнэлгийн цахим гэрчилгээ хонь, тэмээний ноос- 5999 ширхэг, арьс- 100 ширхэг, ноолуур- 60764 кг-д гэрчилгээ бичигдсэнийг хянан баталгаажуулсан.	90%
23	3. Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шаардлагатай эм, бэлдмэл, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх	2021 - 2024	0	5.000.000	15		Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шаардлагатай эм, бэлдмэл, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн халдвартгүйтгэлийн бодис- 300 кг, халдварт хамгааллын хувцас- 100 ширхгийн нөөцтэй байна.	90%
<b>4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>								
24	4.3.5. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд бүх	1. Авлигын гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, шударга байдлын төвшинг	2021 - 2024	5 70 45.8		2 72 48	Хууль, эрх зүйн мэргэжилтэн нь бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчидтай хамтран “Хууль зүйн мэдээллийн цаг”-ийг сумын төвд 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар	90%

1	2	3	4	5	6	7	8	9
	нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.	нэмэгдүүлэн, цахим хуудасны ил тод байдлын төвшинг ахиулах					сарын 01-ний өдрийг хүртэл 2 сарын хугацаатайгаар нийт 18 удаагийн сургалтыг долоо хоногийн Пүрэв гараг бүр бусад төрийн албан хаагчтай хамтран зохион байгуулсан. Энэхүү сургалтаар шинэчлэгдсэн хууль тогтоомжийн талаар мэдээлэл хүргэж ажилласан. Сумын албан ёсны вэб сайт shinejinst.bkh.gov.mn хаягт төсвийн мэдээллийг Санхүү албаны тухайн жилд батлагдсан төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг мэдээллийг олон нийтэд ил тод байлгах үүднээс сайтад байршуулан ажиллаж байна. Hural.mn сайтад төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг байршуулдаг. Сумын фэйжид ОНХС-н мэдээлэл, төсөв санхүүгийн мэдээллийг тухай бүр нийтэлдэг.	
25	4.5.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдэд эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлнэ.	1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, иргэдийн эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх	2021 - 2024	1000		1600	Сумын хэмжээнд 4 багийн иргэдийн нийтийн хурлыг хамтатган хийсэн бөгөөд уул уурхайн асуудал болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хүрээнд хийж нийт 1050 иргэн хамрууллаа. Багуудын Иргэдийн нийтийн хурал 2023 оны 10 дугаар сарын 13-наас 2023 оны 15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, иргэдэд төрийн албан хаагчид сургалт мэдээллийг хүргэсэн ба Байгаль орчин, уул уурхай, хог хаягдал, ундны усны чиглэлээр мэдээлэл, сургалтыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч баг тус бүр 1 удаа хийж, Зараа 1 дүгээр багийн Иргэдийн нийтийн хуралд 53 өрхийн 68 иргэн, Уртын гол Багийн Иргэдийн нийтийн хуралд 104 өрхийн 136 иргэн, Эрдэнэшанд багийн Иргэдийн нийтийн хуралд 89 өрхийн 106 иргэний төлөөлөл хуралд оролцож нийт 310 иргэнд сумын Байгаль орчны чиглэлээр хийгдэж байгаа болон	100%

1	2	3	4	5	6	7	8	9
							цаашид хийгдэх ажлууд, Байгаль орчны холбоотой хуулийн танилцуулга, мэдээлэл хийгдсэн. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, ногоон хөгжил тогтвортой хөгжлийн боловсрол олгох сургалт, арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 1000 гаруй иргэнд хүргэж ажиллалаа.	
26	4.6.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчинээр хангаж, архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулах.	2. Төрийн болон байгууллагын архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах.	2021 - 2023	183 , 13	Нягтруулсан шүүгээ 2 ийг байгууллагын төсвээс 2500 000 төгрөгөөр, хамгаалалтын хайрцаг, баримтын хавтас авахад бичиг хэргийн төсвээс 1 720 000 төгрөг зарцуулав.	70 , 0	Байгууллагын 2001-2022 оны баримтын нэгдсэн тооллогыг явуулж баримт бүрийг хуудсаар нь тоолж нүүр, ашиглалтын, баталгааны хуудсыг засаж янзлах шаардлагатай баримтуудыг засаж нэгдсэн мэдээг төрийн архивын тасагт хүргүүлсэн. Нийт 1064 баримтын 44825 хуудас баримттай байна. Засаг даргын Тамгын газар 1996-2022 оны баримтын тооллогыг явуулж баримтын хуудас бүрийг нягтлан шалгаж тоолов тэмдэглэгээ хийж дүн мэдээг төрийн архивд хүргүүлээд байна. Байгууллагын архивд 6 нягтруулсан шүүгээ байршуулж 1996-2022 оны 312261 хуудас бүхий 2964 хадгаламжийн нэгж байгууллагын архивд байна.	100%
27	Сургууль-Аймгийн төрийн архивын 2023 оны сумдын архивын баримт хүлээн авах төлөвлөгөөний дагуу байгууллагын 2020 оны баримтыг цаасан болон цахим хэлбэрээр төрийн архивд хүлээлгэн өгсөн. Байгууллагын байнга хадгалах 47 баримтын 475 хуудастай баримтыг аймгийн төрийн архивын санд хүлээлгэн өгсөн байна. Засаг даргын Тамгын газар-2019, 2020 оны баримтын дансанд байгууллагын нэрийн өөрчлөлт, товч танилцуулга, 2019 оны байнга хадгалах хадгаламжийн нэгж 136, 70 жил хадгалах 8	3 . Төрийн болон байгууллагын архивын баримтын цахим санд шилжилтийг эрчимжүүлэх.	2021 - 2024	77,4	Төрийн архивт хүлээлгэж өгөхөд байгууллагын бичиг хэргийн зардлаас хамгаалалтын хайрцаг, баримтын хавтас авахад 860000 төгрөг зарцуулав.	86		100%

1	2	3	4	5	6	7	8	9
							хадгаламжийн нэгжийн бүртгэл, Түр хадгалах 140 хадгаламжийн нэгжийн бүртгэл, 2020 оны байнга хадгалах хадгаламжийн нэгж 141, түр хадгалах 175, 70 жил хадгалах 26 баримт, товчилсон үгийн жагсаалт, зүйлийн заагч, ашигласан номын жагсаалтыг бичиж архивын тасгийн дарга В.Эрдэнэчимэгээр хянуулан, сканердаж цэвэрлэн данс болгон цахим хувийг цаасан баримттай тулган 277 байнга хадгалах баримтын 7503 хуудсыг агуулга, газар зүйн нэр, хүний нэр, байгууллагын нэр гэсэн 4 өгөгдөл шивж Jpg өргөтгөлөөс Pdf өргөтгөлд хөрвүүлэн архивын AMSexe программын өгөгдөл холбон сум хариуцсан ажилтан хуулан өгч, Б.Оюунтуяд 2019 оны байнга хадгалах 136, 2020 оны 141 баримтыг хавтаслан хайрцаглаж аймгийн Төрийн архивын тасгийн дэргэдэх БНШАЗКомиссын хурлаар батлуулан сумын Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Оюунгэрэл, Тамгын газрын операторч Г.Батчимэг, Архивын ажилтан Д.Цэвэлмаа нар төрийн архивд хүлээлгэн өглөө.	
28	4. Төрийн болон байгууллагын архивын баримтыг сэлбэн засах.	2021 - 2024	0	0,22	Байгууллагын 2001-2022 оны баримтын нэгдсэн тооллогыг явуулж баримт бүрийг хуудсаар нь тоолж нүүр, ашиглалтын, баталгааны хуудсыг засаж янзлах шаардлагатай баримтуудыг засаж нэгдсэн мэдээг төрийн архивын тасагт хүргүүлсэн. Нийт 1064 баримтын 44825 хуудас баримттай байна.	90%		
<b>5. ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>								
29	5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний	2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний	2021 - 2024	24268, 88	17500000	50000,50	3. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд: Мод тарих ажлыг эрчимжүүлэх тухай сумын Засаг даргын захирамжийг төлөвлөн	100%

1	2	3	4	5	6	7	8	9
хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ.	хүрээнд 20 сая мод тарих						гаргуулж, хэрэгжүүлж ажиллалаа. Бүх нийтээр мод тарих ажлыг сумын ойн зурvas газарт зохион байгуулж, нийт 68 иргэн хамрагдан ажиллаж 1500 мод таригдсан. “Сэker ресорсус” ХХК 1000 суулгац, ерөнхийлөгчийн туслах Даваадалай 850 суулгац өгч мод тарих сонирхолтой иргэдэд тарааж өгөх, модны талбайд нөхөн тарилт хийх зэргээр ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажилласан. “Эрдэнэ Монгол” ХХК энэ онд 62000 ширхэг мод үрээр үргүүлсэн байна. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд “Амралтаараа ажиллая” оюутан хөтөлбөр хэрэгжүүлж, 19 оюутан ЗДТГ-ын албан хаагчдад дагалдах ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ мод арчлах, услах ажлыг хийлцэж ажилласан нь ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд тус дэм болсон ажлын нэг байлаа. “Амралтаараа ажиллая” хөтөлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэмонгол” ХХК хэрэгжүүлсэн бөгөөд уг хөтөлбөрт хамрагдсан 19 оюутан залуусыг ногоон байгууламж, мод тарих арчлах ажилд оролцуулж ажилласан. Засаг даргын захирамжийн хүрээнд сумын хэмжээнд модны тооллого зохион байгуулсан бөгөөд нийт 8250 мод ургаж байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналд “Аман шүүт”-ийн “модны талбайн усалгааг нарны өргүүртэй худагтай болгох” асуудлыг оруулж батлуулан, тодотголоор санхүүг шийдвэрлүүлснээр “Рентек” ХХК 17500000 төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэн орон нутагт хүлээлгэн өгсөн бөгөөд шатахуун, цаг зав хэмнэсэн, тарьсан мод усаар	

1	2	3	4	5	6	7	8	9
							дутагдахгүй байх нөхцөл бүрдсэн нь сайн талтай, үр дүнтэй ажил боллоо.	
30	5.2.1. Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах ажлыг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.	1. Булгийн эхийг хамгаалж, ундаргыг сэргээх, хөв байгуулах	2021 - 2024	6	Хувийн болон төсөл хөтөлбөрөөр хэрэгжсэн.	3	Монголын унаган байгалийн хүлцэл тогтвортой хангах нь төслийн 13 сая төгрөгийн санхүүжилтээр "Хаяа" булгийн эхийг хамгаалах ажлыг "Дошуур чулуут" ТББ хариуцан гүйцэтгэж орон нутагт хүлээлгэн өгсөн бөгөөд малчин идэвхтэн байгаль хамгаалагч Х.Одонтунгалагт хариуцууллаа. Сумын төвийн ундны усны хангамжийн эх үүсвэрийг сайжруулах зорилгоор "Эрдэнэ Монгол" ХХК иргэдээс гаргасан санал хүсэлтийн дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн 100 хувийн санхүүжилтээр усны эх үүсвэрийн байгууламжийг бий болгосон. НҮБ-ын санхүүжилтээр нэг худаг тохижуулах ажлыг хариуцагч аж ахуйн нэгж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Энэ худгаас сумын төвийн иргэд ногоон байгууламж болон ахуйн хэрэглээнд үнэ төлбөргүйгээр хэрэглээ хийж байна.	100%
31		2. Малчид, нөхөрлөлүүдтэй хамтран байгаль орчноо хамгаалах нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулах	2021 - 2024	400		150	Малчдын бүлгээс сонгон 12 иргэнийг идэвхтэн байгаль хамгаалагчаар ажиллуулж байна. Идэвхтэн байгаль хамгаалагчид уул уурхайтай холбоотой 4 зөрчилд санал гомдол ирүүлж нийт 5000000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг авхуулахад үүрэг гүйцэтгэсэн байна. Малчдын цуглаан 2 удаа зохион байгуулагдаж, цугларсан иргэдэд Байгаль орчныг хамгаалах тухай хуулиас болон тусгай зөвшөөрлийн талаар мэдлэг олгох, мэдээлэл өгч ажилласан бөгөөд нийт 510 иргэн хамрагдсан.	100%
32	5.2.2. Зэрлэг амьтдыг хамгаалах өвс.	1. Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах	2021 - 2024	2	6200000 орон нутгийн	3	Тус сумын нутагт ангийн бүс нутгаар "Агът" бүс нутаг тодорхойлогдсон бөгөөд зэрлэг ан амьтанд зориулсан биотехникийн арга	100%

1	2	3	4	5	6	7	8	9
	тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулна				хөгжлийн сангаас		хэмжээг уг ангийн бүс нутагт голчлон тавьж хэрэгжүүлж байна. 2023 оны 1дүгээр сар, 3 дугаар сар, 4 дүгээр сар, 5 дугаар сар, 6 дугаар саруудад 8 цэгт 5 удаагийн давтамжаар өвс тавих, хужир тавих ажлыг Засаг даргын Тамгын газрын хамт олон, Байгаль орчны ажилтнууд хамтран нийт 33 иргэн оролцож, тавьж ажилласан. Биотехникийн арга хэмжээнд нийт 6200000 төгрөг зарцуулсан байна. “Цоохондойт уулынхан” ТББ Дулаан, Хиагтын ууланд 40 боодол өвс хүргэж ажилласан. ГИДЦГ-ын бүс нутагт мазаалайг ичээнээс гарах үед пунктт тэжээл тавих ажилд Байгаль хамгаалагчид хамтран оролцсон.	
33	5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана.	1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2021 - 2024	40	Хувь аж ахуйн нэгж өөрийн хөрөнгөөр	70	Хүн амыг шаардлага хангасан ундны усаар хангах ажлыг "ЭрдэнэМонгол" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдээс гаргасан саналын дагуу ундны усны байгууламжийг барьж, шүүлтүүртэй ус түгээх байр, холболтыг хийж ажилласан. Ундны усыг 3 удаа шинжилгээнд хамруулж, ямар нэгэн үзүүлэлт давсан зүйлгүй байна.	100%

  
 ХЯНАСАН  
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
 ДАРГА  Л.БАТХУЯГ  
  
 БИЕЛЭЛТ ГАРГАСАН  
 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
 МЭРГЭЖИЛТЭН  Г.БАТЧИМЭГ

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН  
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

2023 оны 12 дугаар сарын 15

Залаа

<b>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО</b>				
<b>Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 33</b>				
Үүнээс	Үр дүнтэй	100%	24	
	Тодорхой үр дүнд хүрсэн	70-90%	8	
	Эрчимжүүлэх шаардлагатай	30-50%	1	
	Үр дүнгүй	0%	-	
	Хэрэгжих хугацаа болоогүй	Х.Б	-	
	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилт <b>95</b> хувьтай байна.			

ооо